



МОНГОЛ УЛС ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2013 оны 5 дугаар
сарын 06 -ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар
хот

Нийтлэг журам батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 16, 17, 18 дугаар зүйл, 23 дугаар зүйлийн 23.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 186 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам"-ыг нэгдүгээр, "Гамшгаас хамгаалах улсын албаны удирдлагын бүтэц"-ийг хоёрдугаар, "Гамшгаас хамгаалах улсын албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар"-ыг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.
2. Дээрх журмыг баримтлан гамшгаас хамгаалах улсын албаны штабыг 2013 оны 05 дугаар сарын 15-ны дотор байгуулж, "Гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-г 2013 оны 3 дугаар улиралд багтаан боловсруулж батлуулахыг гамшгаас хамгаалах улсын албаны дарга нарт даалгасугай.
3. Гамшгаас хамгаалах улсын албаны үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлж, хамтран ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга /Т.Дуламдорж/-д үүрэг болгосугай.
4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын 2004 оны 46 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Шадар сайд

Д.ТЭРБИШДАГВА

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ АЖИЛЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхэд гамшгаас хамгаалах улсын алба /цаашид Улсын алба гэх/-ны гүйцэтгэх нийтлэг чиг үүргийг тодорхойлох, түншлэл хамтын ажиллагаа, салбар хоорондын удирдлага, зохицуулалтыг уялдуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Улсын алба нь гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангана.

1.3. Улсын алба нь гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, бэлэн байдлыг хангах, нөөц бүрдүүлэх, сургалт, дадлага зохион байгуулах, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, бусад улсын албатай харилцан ажиллах, мэдээлэл солилцох зэрэг арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.

1.4. Улсын албаны дарга нь тухайн төрийн захиргааны төв байгууллагад сайд, төрийн захиргааны байгууллагад дарга нь байх бөгөөд улсын албаны удирдлага /цаашид “штаб” гэх/-ыг энэхүү журамд заасны дагуу томилгоожуулан удирдана.

1.5. Улсын алба нь гамшгаас хамгаалах асуудал хариуцан ажиллах орон тооны албан хаагчтай байна.

1.6. Улсын алба нь энэхүү нийтлэг журмын хүрээнд эрхэлсэн салбарын онцлогийг тусгасан журам боловсруулан мөрдөж болно.

Хоёр. УЛСЫН АЛБАНЫ ЧИГ ҮҮРЭГ

2.1. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагаас гамшгаас хамгаалах чиглэлээр гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

2.2. Эрхлэх асуудлын хүрээнд салбарын бодлого, хөгжлийн хэтийн төлөвлөлттэй уялдуулан гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө /цаашид “гамшгаас хамгаалах төлөвлөгөө” гэх/ боловсруулж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд, тухайн улсын албаны даргаар батлуулах;

2.3. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих;

2.4. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах, зарцуулах, үр дүнг тооцох;

2.5. Эрхэлсэн асуудлын хүрээнд гамшгаас хамгаалах чиглэлээр баримтлах дүрэм, журам, заавар, стандарт, норм, норматив боловсруулах;

2.6. Үүссэн болон үүсч болзошгүй гамшгийн нөхцөл байдлыг үнэлж дүгнэх, мэргэжлийн заавар, зөвлөмж, мэдээллээр онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, Улсын онцгой комисс, Засгийн газрыг цаг тухайд нь шуурхай хангах, холбогдох шийдвэр гаргуулах;

2.7. Гамшгаас хамгаалах чиглэлээр эрхэлсэн салбарын хэмжээнд албан даалгавар, удирдамж гаргах, биелэлтийг шалгах, холбогдох албан тушаалтны илтгэл мэдээлэл сонсох;

2.8. Гамшгийн үед салбарын тогтвортой ажиллагааг хангах нөхцлийг бүрдүүлэх, шаардлагатай үед ажлын тусгай горимд шилжүүлэх, гамшгийн голомтод хүч хэрэгслийг шуурхай томилон ажиллуулах;

2.9. Эрхэлсэн салбарын хэмжээнд гамшгийн аюулын зарлан мэдээлэл дамжуулах тогтолцоог бүрдүүлэх, дохиогоор ажиллах дадлага сургуулийг хийх, зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

2.10. Хууль тогтоомжийн хүрээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, улсын албадад томилгоот хүч хэрэгслээр дэмжлэг үзүүлэх, харилцан ажиллах;

2.11. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, тайланг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улс, орон нутгийн албанаас гаргуулан авах, мэдээллийн сан бүрдүүлэх;

Гурав. ШТАБЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Улсын албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж батлуулах, албаны ажлыг сар, улирал, жилээр төлөвлөх.

3.2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, эрсдэлийг бууруулах, гамшгийн үед салбарын тогтвортой ажиллагааг хангах ажлыг зохион байгуулах.

3.3. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай хүч хэрэгслийн нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах, хяналт тавих.

3.4. Эрхэлсэн салбарын хэмжээнд гамшгийн даатгал, санхүүгийн болон эрсдэлийн сантай холбоотой эрх зүйн зохицуулалт бий болгох.

3.5. Гамшгийн тухай мэдээ, мэдээллийг цуглуулах, нөхцөл байдлыг үнэлж, дүгнэх, шийдвэрийн төсөл боловсруулах, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

3.6. Улсын албаны удирдлагын баримт бичгийг төлөвлөх, хүч хэрэгслийг томилгоожуулах, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг сургаж дадлагажуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.

3.7. Гамшгийн зарлан мэдээллийг тодотгох, гамшгаас хамгаалах чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулах, сургалтын материал, гарын авлага боловсруулах.

3.8. Бусад улсын алба болон Онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажиллах төлөвлөгөөнд жилд нэгээс доошгүй удаа, гамшгийн үед тухай бүр тодотгол хийх, харилцан ажиллагааг зохион байгуулах.

3.9. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг тусгай хувцас, хүн нэг бүрийн болон хамтын хамгаалах хэрэгслээр хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартын дагуу ажиллах нөхцлийг бүрдүүлэх.

3.10. Гамшгийн голомтод ажилласан албан хаагчдын ажлын үр дүнг харгалзан урамшуулах.

3.11. Гамшгийн нөхцөл байдлын мэдээ, мэдээлэл, улсын албаны шийдвэрийг холбогдох улсын болон орон нутгийн алба, төрийн байгууллага, иргэдэд шуурхай хүргэх.

3.12. Орон нутгийн алба, мэргэжлийн ангиас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээг хүлээн авч нэгтгэх, улсын албанаас авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, холбогдох бусад материалыг Онцгой байдлын ерөнхий газарт жил бүрийн 6 дугаар сарын 30, дараа оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлэх.

Дөрөв. ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

4.1. Штаб нь дараах албан тушаалтнаас бүрдэнэ. Үүнд:

4.1.1. Штабын дарга-төрийн захиргааны төв байгууллагад Төрийн нарийн бичгийн дарга, төрийн захиргааны байгууллагад дэд дарга байна.

4.1.2. Штабын орлогч-тухайн төрийн захиргааны байгууллагын төрийн захиргааны асуудал хариуцсан нэгжийн дарга байна.

4.1.3. Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны албан хаагч-тухайн төрийн захиргааны байгууллагын үндсэн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэдэг зохион байгуулалтын нэгжийн ажилтан байна.

4.1.4. Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан-тухайн төрийн захиргааны байгууллагын мэдээлэл, холбооны асуудал хариуцсан нэгжийн дарга байна.

4.1.5. Сургалт, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдал хариуцсан ажилтан-тухайн төрийн захиргааны байгууллагын сургалтын асуудал хариуцсан нэгжийн дарга байна.

4.1.6. Ар тал, хангалт хариуцсан ажилтан-тухайн төрийн захиргааны байгууллагын санхүү, хангалтын асуудал хариуцсан нэгжийн дарга байна.

4.1.7. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал хариуцсан ажилтан-тухайн төрийн захиргааны байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан албан тушаалтан байна.

4.1.8. Бусад-эрхэлсэн салбарын болон гамшгийн нөхцөл байдал /нөлөөлөл, хамрах хүрээ, цаг хугацаа, болзошгүй хохирол, үр дагавар/-ын онцлогоос шалтгаалан холбогдох албан тушаалтан, ажлын хэсгийг тухай бүр томилон ажиллуулж болно.

4.2. Штабын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд нөхөн томилгоо хийж Онцгой байдлын ерөнхий газарт тухай бүр мэдэгдэнэ.

Тав. СУРГАЛТ

5.1. Гамшгаас хамгаалах сургалт дадлагыг Улсын алба, онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгаж, хөтөлбөр, удирдамжийн дагуу зохион байгуулна. Үүнд:

5.1.1. Улсын албаны удирдлага, штабын бүрэлдэхүүний хамтарсан сургалт дадлагыг 2 жил тутамд нэг удаа;

5.1.2. Мэргэжлийн ангийн дадлага сургалтыг жил бүр;

5.1.3. Үүсч болзошгүй гамшгийн нөхцөл байдал, гамшгийн эрсдэл, давтамжийг харгалзан шаардлагатай сургалт, дадлагыг тухай бүр;

5.2. Улсын албад хоорондын хамтарсан сургалт дадлагыг албадын дарга нарын шийдвэрээр зохион байгуулна.

5.3. Онцгой байдлын ерөнхий газар нь улсын албадын хамтарсан сургалт дадлагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

Зургаа. БУСАД

6.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оруулсан хувь нэмрийг нь харгалзан улс, орон нутгийн гамшгаас хамгаалах томилгоот албан хаагчийг онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын болон Онцгой байдлын ерөнхий газрын шагналаар шагнаж болно.


6.2. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэсэн албан хаагчийн томилолтын зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу ердийн үеийнхээс гурав дахин өсгөж олгоно.

6.3. Гамшгаас хамгаалах үүрэг гүйцэтгэх үед хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон, амь насаа алдсан тохиолдолд албан хаагч болон түүний гэр бүлд тэтгэмж, нөхөн олговор олгох асуудлыг Гамшгаас хамгаалах тухай хууль, холбогдох бусад хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

6.4. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, техник, хэрэгсэл, хөрөнгийг зориулалт бусаар ашиглах, бусад албаны дотоод асуудалд оролцохыг хориглоно.

6.5. Улсын албаны үйл ажиллагааг Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу шалгаж, үнэлнэ.

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ УДИРДЛАГА /ШТАБ/-ЫН БҮТЭЦ



БАТЛАВ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА
Огноо

БАТЛАВ

ГАМШГААС ХАМГААЛАХ
УЛСЫН АЛБАНЫ ДАРГА.....
/албан тушаал/ САЙД /ДАРГА/
Огноо

..... /улсын албаны нэр/ УЛСЫН АЛБАНЫ

ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

УЛААНБААТАР ХОТ

2013 ОН

..... УЛСЫН АЛБАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ

д/д	Бүтэц	Хуудасны дугаар
А	Үндсэн төлөвлөлт	
1	Нийтлэг үндэслэл	
2	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, /Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох арга хэмжээ/	
Б	Хавсралт хэсэг	
3	Төлөвлөгөөний хавсралтууд/ судалгаа, тооцоо/	
В	Мэдээллийн хэсэг	
4	Улсын албаны танилцуулга	
5	Улсын алба байгуулсан тухай шийдвэр /удирдлагын бүтэц/	
6	Улсын албаны штабын гишүүдийн ажил үүргийн хуваарь	
7	Улсын албаны зарлан мэдээлэл дамжуулах бүдүүвч	
8	Эрхэлсэн салбарын хэмжээнд тохиолдсон гамшгий н сургамж, давтамжийн судалгаа, дүгнэлт	
9	Байр зүйн зураг	
	Г.М	

..... УЛСЫН АЛБАНЫ ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү төлөвлөгөө нь тохиолдож болзошгүй аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтээс урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг эрхэлсэн салбарын хэмжээнд зохион байгуулах улсын албаны удирдлагын баримт бичиг болно.

1.2. Төлөвлөгөөг 3 хувь үйлдэх бөгөөд хувийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд /Шадар сайдын ажлын алба/, гамшгаас хамгаалах улсын алба, Онцгой байдлын ерөнхий газарт тус тус хадгална.

1.3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээний зардлыг улсын болон эрхэлсэн салбарын тогтвортой байдал, хөгжлийн хэтийн төлөвлөлтөд тусгаж хэрэгжүүлнэ.

1.4. Төлөвлөгөөнд Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу бэлэн байдлын зэргүүдэд шилжсэн үед хэрэгжүүлэх арга хэмжээг тусгана.

1.5. Төлөвлөгөөнд тусгах гамшгийн холбогдолтой нэр томъёог “Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт, ерөнхий анги” MNS 6010:2009 улсын стандартад тодорхойлсноор хэрэглэнэ.

Хоёр. ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ, АРГА ХЭЛБЭР

Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь үүсч болзошгүй болон үүссэн гамшгийн үед хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, аюулгүй байдлыг хангах, урьдчилан төлөвлөгдсөн, шуурхай, уян хатан, тасралтгүй байх, хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй ашиглах үндсэн зарчмын хүрээнд “хийж гүйцэтгэх ажил”, “хэрэгжүүлэх арга зам”, “хугацаа”, “хариуцах эзэн /хүн/”, “хамтран хэрэгжүүлэх байгууллага /алба/”, “шаардагдах зардал” гэсэн асуумжид хариулагдахаар, “удирдлага, зохион байгуулалт,” “гамшгаас урьдчилан сэргийлэх”, “аврах”, “хор уршгийг арилгах”, “сэргээн босгох ажиллагаа” гэсэн үе шатаар төлөвлөгдсөн байвал зохино.

2.1. /гамшгийн нэр, төрөл/ ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэх байгууллага /алба/	Шаардагдах нөөц	Зардал
А. Гамшгийн өмнөх үед						
Б. Гамшгийн үед						
В. Гамшгийн дараах үед						

гэх мэт эрхэлсэн салбарын үйл ажиллагаатай холбоотой гамшгийн төрөл тус бүрт ажиллах арга хэмжээг төлөвлөнө.

2.2. ГАМШИГ ТОХИОЛДСОН ҮЕД ХҮН ХҮЧ, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙГ ДАЙЧЛАН АЖИЛЛУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын төрөл	Бэлэн байдалд шилжих хугацаа /цаг, минутаар/	Байгууллагын нэр	Дайчлагдах хүний тоо	Багаж хэрэгслийн нэр, тоо	Техник хэрэгслийн загвар, хүчин чадал, тоо	Хариуцах албан тушаалтан
1							

гэх мэт эрхэлсэн салбарын үйл ажиллагаатай холбоотой гамшгийн төрөл тус бүрт ажиллах арга хэмжээг төлөвлөнө.

2.3. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын төрөл	Байгууллага	Хүний тоо, /хэнийг ямар хаягаар дайчлан ажиллуулахыг бичнэ/	Техник хэрэгслийн загвар, хүчин чадал, тоо	Хариуцах албан тушаалтан Утасны дугаар, гэрийн хаяг	Хариуцан нүүлгэх объект (ач холбогдлын дарааллаар бичнэ.)	Тайлбар

гэх мэт эрхэлсэн салбарын үйл ажиллагаатай холбоотой гамшгийн төрөл тус бүрт ажиллах арга хэмжээг төлөвлөнө.

2.4. ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ ТАНИЛЦСАН :

д/д	Албан тушаал	Гарын үсэг	Огноо
1			
2			

/г.м тухайн гамшгаас хамгаалах улсын албаны штабын бүрэлдэхүүн танилцсан байна/

Гурав. УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАД, МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ТОМИЛГОО, ХҮЧ ХЭРЭГСЭЛ, НӨӨЦИЙН ХАНГАМЖ, БЭЛЭН БАЙДАЛ

3.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажлыг Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу өөрийн салбарын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд болон холбогдох төрийн байгууллага, бусад улсын албадтай хамтран хэрэгжүүлнэ.

3.2. Эрхэлсэн салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах улсын алба..., орон нутгийн алба, мэргэжлийн анги..., нийт хүн, гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл..., үүнээс техник...,багаж хэрэгсэл байна. Хүч хэрэгслийг (... дугаар хавсралтад) үзүүлэв.

3.3. Улсын албаны гамшгаас хамгаалах нөөцийн хангамж 20..оны ...сарын байдлаар ...: хувийн хангалттай байна. Үүнд: - ямар нөөц хэрэгсэл байгааг бүгдийг төрөл тус бүрээр гаргаж бичнэ.

Дөрөв. ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТ (СУДАЛГАА, ТООЦООНЫ ХЭСЭГ)

Төлөвлөгөөний хавсралтад хүч хэрэгсэл, холбоо зарлан мэдээлэл, мэдээллийн сан, сүлжээ, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, сургалт дадлага, бүх төрлийн хангалт, нөөц бүрдүүлэх, барилга, байгууламж, онц чухал объектын судалгаа зэрэг тооцоо, судлагааг нарийвчлан тусгавал зохино.

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ ХҮЧ ХЭРЭГСЛИЙН ТООЦОО /Хавсралт 1/

д/д	Мэргэжлийн ангийн нэр	Томилгоот хүч хэрэгсэл			Дайчилгаагаар ажиллах хүч хэрэгсэл		
		хүн	техник	Багаж хэрэгсэл	хүн	техник	Багаж хэрэгсэл

Жич: Гамшгаас хамгаалах улс, орон нутгийн алба, мэргэжлийн ангиудаас гаргасан тооцоог нэгтгэнэ.

ГАМШГИЙН НӨӨЦИЙН ТООЦОО /Хавсралт 2/

№	Бүрдүүлэх нөөцийн нэр	Шаардлагатай хэмжээ	Бэлэн байгаа	Нөхөн бүрдүүлэх			
				Байршил	Тоо, хэмжээ	Зарцуулагдах хугацаа	Арга хэлбэр
1							
2							

УЛСЫН АЛБАНЫ УДИРДЛАГЫН ГЭРИЙН ХАЯГ, УТАСНЫ ЖАГСААЛТ, БИЕ ХОЛБООЧИН /Хавсралт 3/


№	Штабын бүрэлдэхүүн	Овог, нэр	Албан тушаал	Гэрийн хаяг, утасны дугаар /иридиум утас/	Зарлан мэдээлэл хүргэх бие холбоочин, түүний утас
1					
2					

УЛСЫН АЛБАНЫ ТОМИЛГООТ АЛБАН ХААГЧДЫН УТАСНЫ ЖАГСААЛТ /Хавсралт 4/

№	Холбогдох албан тушаалтан	Тухайн албан хаагчийн гамшгийн үед эрхлэх ажил	Овог, нэр	Үүрэн телефон утас	Ажлын утас, гэрийн утас	Бусад
1						

(гэх мэт бүх томилгоот албан хаагчдын утасны жагсаалтыг бичнэ.)

ГАМШГИЙН ҮЕД МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ БҮДҮҮВЧ /Хавсралт 5/



**ЭРХЭЛСЭН САЛБАРЫН ХЭМЖЭЭНД АШИГЛАЖ БАЙГАА ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДУУТ ДОХИО ДАМЖУУЛАХ
ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН БАЙРЛАЛ**

/Хавсралт 6/

д/д	Дуут дохионы байрлал	Хариуцсан даргын нэр, албан тушаал, утас	Техник хариуцсан албан тушаалтан, утас	Үйлдвэрлэсэн улс, ашиглалтад орсон он, сар, өдөр	Ажиллагаа, иж бүрдлийн байдал

ЭРХЭЛСЭН САЛБАРЫН ХЭМЖЭЭНД БАЙГАА ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫН СУДАЛГАА

/Хавсралт 7/

№	Байгууллагын нэр	Барилга байгууламжийн тоо,	Ашиглалтад орсон он, насжилт	Барилгын бүтэц	Барилгын эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ

ЭРХЭЛСЭН САЛБАРЫН ХЭМЖЭЭНД АШИГЛАЖ БАЙГАА БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН СУДАЛГАА

/Хавсралт 8/

№	Байгууллагын нэр	Барилга байгууламжийн зориулалт	Ашиглалтад орсон он	Барилгын хийц, бүтээц	Барилгын эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ
	Бүгд				

Тав. ГАМШГААС ХАМГААЛАХУЛСЫН АЛБАНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА /Мэдээлэл хэсэг/

Танилцуулгад дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:

- 2.1. Улсын албаны нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүрэг
- 2.2. Гамшгийн мэдээллийн сан /гамшгийн тохиолдол, төрөл, учруулсан хохирол, хүн ам зүй г.м/
- 2.3. Орон нутгийн гамшгаас хамгаалах албатай ажиллах уялдаа, холбоо /бүдүүвч/
- 2.4. Нөөцийн хангамж /тухайлбал гамшгийн үед ажиллах албан хаагч, хэрэглэгдэх материал хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, тэдгээрийн бэлэн байдал г.м/
- 2.5. Гамшгаас хамгаалах чиглэлээр зайлшгүй баримтлан ажиллах шаардлагатай /салбарын онцлогыг харгалзан/ норм, норматив, стандарт
- 2.6. Бусад

..... УЛСЫН АЛБАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТОДОТГОЛ ХИЙСЭН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

д/д	Төлөвлөгөөг тодотгосон албан тушаалтан, овог нэр	Тодотгол хийсэн он, сар, өдөр	Хуудасны дугаар	Мөрийн дугаар	Тодотгол хийсэн товч утга

.....оОо.....